



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/99

Ховд

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1, 10.4.5, 10.4.7, 10.4.8, 10.4.12, 10.4.17 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зудын гамшигтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гамшгийн нөөцийг аймгийн хэмжээнд нэмэгдүүлэх, стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл, эмнэлгийн анхан шатны болон сэтгэл заслын тусламж үзүүлэх болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох мэргэжлийн байгууллагын дарга нарт даалгасугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Улсын Онцгой комиссын Шуурхай штабын мэдээ мэдээллээр дамжуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (О.Хүрэлбаатар), Эрүүл мэндийн газар (Ц.Мягмарсүрэн), Мал эмнэлгийн газар (Ц.Батцэнгэл), Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Г.Цоодол), Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Б.Алтанбадралт)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Х.Батболд), Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Б.Алтанбадралт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400021 0037  
Zah A/99 Kh